



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЛТАНШИРЭЭ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 9/26

Чулуунгишгэр

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйл, 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газраас иргэдэд мэдээлэл олгох журмыг хавсралтаар баталсугай.


2.Дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг байгууллагын албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (А.Мядагмаа)-д даалгасугай.

ДАРГА  М.БААСАНЖАВ

9226908. ЭТ0167. 0622040021

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын
2023 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн
№/26 дугаар тушаалын хавсралт



АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.

1.2. Засаг даргын Тамгын газрын архивын болон төрийн албан хаагчдын хариуцсан мэдээлэл (цаашид "мэдээллийн сан" гэх) дахь нээлттэй, хязгаарлалттай мэдээллээс иргэн, хуулийн этгээд болон хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтанд лавлагаа, мэдээлэл өгөхөд энэ журмыг баримтална.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "лавлагаа" гэж мэдээллийн санд үндэслэн бүртгэлийн мэдээллийн үнэн зөвийг нотолсон цахим болон цаасан баримт бичгийг;

1.3.2. "мэдээлэл" гэж мэдээлэл сан хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг;

1.3.3. "нээлттэй мэдээлэл" төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээлэл;

1.3.4. "хязгаарлалттай мэдээлэл" нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан мэдээллийг хэлнэ.

ХОЁР. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛЭЭС ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

2.1. Энэ журмын 1.3-д заасны дагуу нээлттэй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд цаасаар болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр олгоно.

2.2. Нээлттэй мэдээлэл авах бол хүсэлтийг амаар болон бичгээр гаргана.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЯЗГААРЛАЛТТАЙ МЭДЭЭЛЛЭЭС ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

3.1. Энэ журмын 1.3-д заасны дагуу хязгаарлалттай мэдээллээс лавлагаа, мэдээллийг дараахь баримт бичгийг үндэслэн өгнө:

3.1.1.иргэн бол өөрийнх нь гаргасан хүсэлт, мэдүүлэг, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл;

3.1.2.хуулийн этгээд бол итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс бичгээр олгосон итгэмжлэл.

3.2.Энэ журмын 3.1-д заасны дагуу хязгаарлалттай мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд цаасаар болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр олгоно. Тухайн мэдээллийг олгоход байгууллагын даргаас зөвшөөрөл авна.

3.3. Хязгаарлалттай мэдээлэл авах бол хүсэлтийг бичгээр гаргана.

3.4. Бичгээр гаргасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгасан байна:

3.4.1.хүсэлт гаргагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр;

3.4.2.хүсэлт гаргагчийн оршин суугаа, эсхүл оршин байгаа газрын хаяг, шуудангийн хаяг, харилцах утасны дугаар;

3.4.3.хязгаарлалттай мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, мэдээллийн эзний зөвшөөрөл;

3.4.4.мэдээллийн агуулга, мэдээлэл хүлээн авах хэлбэр.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ӨГӨХ

4.1.Төрийн цахим үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системээс иргэн, хуулийн этгээд нь иргэний үнэмлэх, тоон гарын үсэг ашиглан цахим хэлбэрээр авч болно.

4.2.Энэ журмын 4.1-д заасан лавлагаа нь "QR" кодоор баталгаажна.

ТАВ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮСЭЛТИЙН ДАГУУ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

5.1.Эрх бүхий албан тушаалтны албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдээллийг өгнө.

5.2.Энэ журмын 5.1-д заасан мэдээлэл нь лавлагаа, хуулбар болон албан бичгийн хэлбэртэй байна.

ЗУРГАА. БУСАД

6.1.Цаасан хэлбэрээр олгосон лавлагаа, мэдээлэл нь архив, албан хэрэг хөтлөлтийн журамд заасан шаардлагыг хангасан байна.

6.2.Энэ журамд заасан мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд холбогдох журмын дагуу олгоогүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---